

Хөгжиж буй Азийн орнуудад нээлттэй худалдаа хамгийн их ач тусаа өгнө

Хонг Конг, БНХАУ (2006.04.06). Дэлхий дахины хоёр талт хэлэлцээр хийх маяг Азийн орнуудад ч ихээр түрэн орж ирж байгаа нь худалдааны нь олон талт тогтолцоонд ихээхэн эрсдэл авчирч болох юм гэж АХБ-ны саяхан гаргасан “Азийн худалдааны чиглэл” гэсэн тайланд анхааруулсан байна.

Нэг талаар ийм эрсдэл нь хөнгөлөлт үзүүлэх ба хөрөнгө оруулалт, худалдааны талаархи шийдвэрүүдийг хүндрүүлдэг буй гарал үүслийн дүрэм журмаас үүсдэг юм гэж илтгэлд дурьджээ. Нөгөө талаар улс орнууд бусдыг гадуурхан худалдааныхаа түншүүдтэйгээ харилцан ашигтай тохиролцоонд хүрэх гэж хүч нөөцөө дахин дайчилж байгаа үед хоёр талын тохиролцооны үзэл олон талт хамтын ажиллагааны үзэлд муугаар нөлөөлж болох магадлалтай.

“Жижиг зах зээлтэй бөгөөд олон улсын зах зээлд бараа бүтээгдэхүүнээ хүргэхэд угийн ноцтой бэрхшээлтэй тулгарч байсан хөгжиж буй орнууд худалдааны шинэ тохиролцоонд хүрэхийн төлөөх өрсөлдөөнд сул байр суурьтай байна. Хоёр талын хамтын ажиллагааны үзэл рүү тэмүүлэх хандлага нь эдгээр ядуу орныг бүр ч гадуурхагдахад хүргэнэ” гэж АХБ-ны ерөнхий эдийн засагч ноён Али хэлжээ.

Өнөөдөр олон нийтэд танилцуулсан АХБ-ны 2006 оны “Азийн хөгжлийн урьдчилсан төлөв байдал” хэмээх АХБ-ны эдийн засгийн хамгийн чухал товхимолд “Азийн худалдааны чиглэл” хэмээх тусгай бүлэг багтжээ.

Сүүлийн 30 жилд олон улсын худалдаа нь орлогын өсөлт болон ядуурлын бууралттай нягт холбоотой явж ирсэн байна гэж товхимолд тэмдэглэжээ. Азийн эдийн засаг хурдацтай өссөн энэхүү хугацааны дийлэнхид экспорт, импортын өсөлт нь орлогын өсөлтөөс давсан байна.

Сүүлийн 20 жилд хөгжиж буй Азийн худалдааны өсөлт гайхмаар байсан байна. Илтгэлд дурьдсанаар 1984-өөс 2004 онд дэлхийн экспорт тав дахин өссөнтэй харьцуулах юм бол энэ бүс нутгийн экспорт бараг 10 дахин нэмэгдсэн байна. Энэ хугацаанд дэлхийн экспорт дахь Азийн экспортын хувь бараг хоёр дахин өсөж 2004 онд 21,3%-д хүрсэн байна.

Худалдааны хоёр талт хэлэлцээрийн тархалт бол хөгжиж буй Азийн тун саяханы онцгой үзэгдэл мөн гэж илтгэлд онцлон тэмдэглэжээ. Дэлхийн худалдааны байгууллага (ДХБ)-ын мэдээлснээр 1995 оноос өмнө АХБ-ны гишүүн хөгжиж буй орнууд зөвхөн гурван ийм хэлэлцээрт оролцсон байна. 2005 он гэхэд 27 гаруй хэлэлцээрийг ДХБ-д мэдэгдсэн бөгөөд үүнээс ч олон тооны хэлэлцээрийг байгуулахаар зэхэж байсан юм. 2006 онд өнөөдрийг хүртэл дахиад өсөн хэлэлцээр байгуулсан тухай ДХБ-д мэдэгдсэн байна. 2006 оны сүүлчээр дэлхий даяар 300 хүртэлх хоёр талт хэлэлцээр хүчин төгөлдөр болно гэсэн зарим тооцоо ч бий.

“Худалдаа нь олон жилийн турш Азийн эдийн засгийн өсөлтийн гол хүчин дэлхийн бусад орнуудтай байгуулж буй хэлэлцээрүүд бүс нутгийн хөгжлийн ирээдүйд ихээхэн тодорхойлох болно” гэж ноён Али хэлжээ.

Тайланд дурьдсаны дагуу, хоёр талт Чөлөөт Худалдааны Хэлэлцээр (ЧХХ) байгуулах нь гуравдагч талын зэх зээлд эзлэх өөрийн хувиа хамгаалах зорилгоор ийм ижил төрлийн хэлэлцээр байгуулах сонирхолыг бий болгох нь олонтаа. Үүний үр дүнд их хэмжээний зардал болон эрсдэл бүхий ямар ч зохицуулалтгүй болон давхардсан олон тооны хэлэлцээрүүд байгуулагддаг.

“Өөрийн эдийн засгийн цар хүрээний ачаар аливаа юманд анхдагч буюу хэлэлцээр хийхэд давуу тал эдлэх чадвартай орнууд ашиг олж чаддаг боловч бусад орнууд, түүний дотор олон ядуу орнууд хохирох эрсдэлтэй” гэж тайланд өгуулжээ. “Дэлхий даяар хоёр талт хэлэлцээрийн тоо асар ихээр өсч байгаа нь олон улсын худалдаанд гарч болох хүндрэлүүд, мөн худалдааны зардалд их хэмжээгээр нөлөөлөх талтай.”

Тайланд дэлхийн эдийн засгийн загвар дээр үндэслэн худалдааг чөлөөлөх нь Азийн орнуудын орлогот хэрхэн нөлөөлж болохыг хэд хэдэн хувилбараар харуулжээ.

Эцсийн үр дүндээ дэлхийн чөлөөт худалдааг бий болгох олон талт хамтын ажиллагааны процессыг ерөнхийдөө “хамгийн оновчтой” шийдэл гэж үзжээ. Энэхүү хувилбарын дагуу 2025 он гэхэд бараа бүтээгдэхүүний чөлөөт худалдаа нь дэлхийн нийт жилийн орлогыг 341.4 тэрбум ам. доллар (2001 оны үнээр)-аар буюу суурь ДНБ-ний 0.5%-тай тэнцэх хэмжээгээр өсгөх тооцоо гарч байна. Азийн хөгжиж буй орнууд үүнээс ихээхэн ашиг олож болох бөгөөд тус бүс нутгийн орлого жилд 152.8 тэрбум ам. доллараар буюу ойролцоогоор суурь ДНБ-ний 1.31%-тай тэнцэх хэмжээгээр өсөх аж.

“Дараагийн хамгийн оновчтой” хувилбарын дагуу Азийн орнууд нээлттэй бүс нутгийн үзлийг дэмждэг Азийн чөлөөт худалдааны онолын бүсийг төлөөлөх худалдааг чөлөөлөх өөрийн гэсэн төлөвлөгөөг боловсруулна. Энэхүү хувилбарын дагуу 2025 он гэхэд бараа бүтээгдэхүүний чөлөөт худалдаа нь дэлхийн нийт жилийн орлогыг 228.56 тэрбум ам. доллар (2001 оны үнээр)-аар буюу суурь ДНБ-ний 0.35%-тай тэнцэх хэмжээгээр өсгөх тооцоо гарч байна. Энэ нь хөгжиж буй Азийн хувьд мөн л эерэг нөлөө авчрах бөгөөд тус бүс нутгийн орлого жилд 133.18 тэрбум ам. доллараар буюу ойролцоогоор суурь ДНБ-ний 1.14%-тай тэнцэх хэмжээгээр өсөх аж.

Сүүлийн жилүүдэд хоёр талт хэлэлцээрийн тоо өссөнтэй холбоотойгоор хоёр талт боомт-ба-дамжлага хэмээх тогтолцоо нь хөгжиж буй Азийн хувьд маш бага үр дүн авчирч байгааг тайланд тусгажээ. Энэ тогтолцоонд боомт болон дамжлагын хоорондын гажуудлыг арилгах боловч дамжлагуудын хоорондын гажуудал хэвээр үлддэг.

Азийн чөлөөт худалдааны хувилбартай харьцуулах юм бол Азийн боомт-ба-дамжлага хувилбарын дагуу Азийн орлого дэлхийн нийт орлогын тавны нэгээс дөрөвний нэгийн хооронд хэлбэлзэнэ. Тайланд гарсан судалгааны дагуу хөгжиж буй Ази дотроо ч боомт-ба-дамжлага тогтолцоо нь бүс нутгийн чөлөөт худалдаа болон олон талт либерализацийн арга хэмжээний давуу талыг гүйцэхгүй.

“Эдгээр хувилбарууд хоёр талт тарифын хөнгөлөлттэй хэлэлцээртэй харьцуулахад олон талт либерализаци нь хавьгүй давуу талтай гэдгийг харуулж байна” гэж ноён Али хэлжээ. Тэрбээр “Хоёр талт хэлэлцээрийн эмх замбараагүй, ямар ч зохицуулалтгүй энэхүү байдлыг арилгах хамгийн оновчтой арга зам нь олон талт либерализацийн хөтөлбөрийг ахиулах явдал юм” гэжээ.

Тайланд мөн тарифын саад тотгор нь асуудлын зөвхөн нэг хэсэг хэмээн тэмдэглэжээ. Боомтын дэд бүтцийн сул хөгжил, гаалийн гажуудалтай болон үр ашиггүй ажиллагаа зэрэг “хилийн цаана дахь” саад тотгор нь ядуу орнуудын бараа бүтээгдэхүүнээ түргэн болон хямд үнээр зах зээлд гаргах гэсэн эрмэлзэлд нь сад тотгор учруулж болно. Эдгээр саад тотгорыг арилгах нь хөгжиж буй Азийн орнуудад эерэгээр нөлөөлөх боломжтой.

Манилад төвтэй АХБ нь ядуу орнуудын эдийн засгийн тогтвортой өсөлт, нийгмийн хөгжил ба сайн засаглалыг дэмжих замаар Ази, Номхон далайн бүс нутагт ядуурлыг бууруулах зорилготой. 1966 онд байгуулагдсан энэхүү банк нь 64 гишүүнтэй бөгөөд тэдгээрийн 46 нь тус бүс нутагт оршдог улс орнууд юм. 2005 онд АХБ-наас нийт 5.8 тэрбум ам. долларын зээл болон 198.8 сая ам. долларын техникийн туслалцааг тус тус баталжээ.

Мэдээний талаар лавлагаа хэрэгтэй бол:

Dave Kruger
Tel: +0918 939-9058
E-mail: dkruger@adb.org

АХБ-ны мэдээний англи электрон хувийг:

ADB Online Media Center: media.adb.org
ADB web site: www.adb.org